



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2018 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 106

Номгон

“Залуучуудын хөгжлийг дэмжих”
аймгийн хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэлийн нэгдүгээр бүлгийн 1.6 дахь заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Залуучуудын хөгжлийг дэмжих” аймгийн хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, шаардлагатай төсөв, арга хэмжээг аймгийн жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсөвт тусгаж батлуулан, үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжилтийг жил бүр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2018 оны 09 дүгээр сарын
19-ний өдрийн 106 дугаар тогтоолын хавсралт



“ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ” АЙМГИЙН ХӨТӨЛБӨР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын хүн амын насны бүтцийн хувьд дэлхийн улс орнуудтай харьцуулахад харьцангуй залууд тооцогддог.

Баянхонгор аймаг нь 2017 оны статистик мэдээллээр нийт 87.243 хүн амтай, хүн амын 35.19 %-ийг залуучууд эзэлдэг. 15-34 насны залуучууд 30.702 байгаагийн 15.673 /51%/ нь эрэгтэй, 15.029 /49%/ нь эмэгтэй байна.

Нийгмийн хөдөлгөгч хүч болсон залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх газар, тэдэнд зориулсан сургалт, үйл ажиллагааны тоо хангалтгүй байна.

Манай аймгийн хувьд 2014-2017 онд НҮБ-ын Хүн амын сангийн төсөл хэрэгжсэн цөөхөн хэдэн аймгийн нэг бөгөөд “Залуучууд хөгжлийн төв”-өөс зохион байгуулсан сургалт, олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд нийт 4360 залуучууд хамрагдсан нь нийт залуучуудын 14.2% байна. Түүнчлэн 26.270 өрх байгаа бөгөөд үүний 7.584 буюу 29.8%-г залуу гэр бүл эзэлдэг. Мөн энэ онд 84 гэр бүл салсаны 37 нь /44%/ залуу гэр бүл байна.

Гэр бүл нь нийгмийн анхдагч нэгж болохын хувьд гэр бүлийн тогтвортой байдлыг бий болгох, залуу гэр бүл рүү чиглэсэн сургалт, мэдээллийн үйл ажиллагааг зохион байгуулах нь зайлшгүй чухал юм.

2017 оны байдлаар нийт 70.422 халдварт бус өвчлөл бүртгэгдсэний 17.485 буюу 21.7% нь 15-34 насанд бүртгэгджээ. 841 осол гэмтлийн тохиолдол бүртгэгдсэний 325 буюу 38.6,% нь энэ насанд бүртгэгдэж, 75.1 %-г эрэгтэйчүүд эзэлж байгаа төдийгүй 443 нас баралтын тохиолдлын 33 буюу 7.4 % нь 15-34 насанд бүртгэгдсэн байна. Нийт нас барсан тохиолдлын 69.7%-г эрэгтэйчүүд эзэлж, 27.3 % нь амиа хорлож, 33.3% нь зам тээврийн ослоор, 3% нь бусдад хорлогдож, 3% нь усанд живж, 33.3% нь өвчнөөр нас баржээ.

Бэлгийн замаар дамжих халдвар 798 тохиолдол бүртгэгдсэний 76.1% нь 15-34 насны залуучууд байна. Үүний 73% нь эмэгтэй, тэдний 45.5% нь жирэмсэн тохиолдол байна. БЗДХ-н тохиолдлын 34.4% нь ажилгүй, 22.5% нь малчин, 15.5% нь оюутан, 27.6%-г албан хаагч, бусад гэсэн үзүүлэлт эзэлж байна.

Өсвөр насны охидын төрөлт манай аймагт улсын дунджаас өндөр байна. 2017 онд 1997 эх төрсөний 7.06% нь 19-с доош насны өсвөр насны охид байна.

Хөдөлмөр эрхлэх насны нийт 23.187 залуучуудын 38.9% хөдөлмөр эрхлээгүй байна. /15-19 насны бүлгийг хасаж тооцсон болно/. Хөдөлмөр эрхлэхээр ажил хайж буй залуучуудын 632 нь ХХҮГ-т бүртгэлтэй байна. Энэ нь нийт ажил хайж буй залуучуудын 19.5%-г эзэлж байна.

Иймд залуучуудыг орон нутгийн шийдвэр гаргах түвшинд оролцоог нэмэгдүүлэх, эрүүл байх, чанартай боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх боломжоор хангах, орлогоо нэмэгдүүлэх, хувийн орон байртай болгох, тэднийг бүх талаар хөгжүүлэх, хамгаалахад чиглэсэн орон нутгийн бодлогыг хэрэгжүүлэх нь нэн чухал асуудал болоод байна.

Хөтөлбөрийг боловсруулах ажлын хүрээнд 20 сумын 1200 залуучуудаас хөтөлбөрийн хэрэгцээ шаардлага, тулгамдаж буй асуудлуудыг санал асуулгаар авч эрэмбэлэн хөтөлбөрт оруулсан бөгөөд боловсруулсан төслөө 1088 залуучуудаар хэлэлцүүлж хөтөлбөртөө тусгасан болно.

Энэхүү хөтөлбөр нь орон нутгийн залуучуудад тулгамдаж буй нийтлэг асуудал, бэрхшээлийг тодорхойлж, залуучуудын утга учиртай оролцоог нэмэгдүүлэх замаар түүнийг шийдвэрлэх арга замыг эрэлхийлж, залуучуудын хөгжлийн хэрэгцээг хангах зорилгоор Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Баянхонгор аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөртэй нягт уялдаатай хэрэгжүүлэх болно.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗАРЧИМ, ХУГАЦАА

2.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим.

2.1.1. Хөтөлбөрийн зорилго, зорилтот үйл ажиллагаа нь залуучуудын эрэлт хэрэгцээнд нийцэхүйц байх

2.1.2 Залуучуудын эрхийг дээдэлсэн, оролцоог хангасан тэгш хүртээмжтэй байх

2.1.3. Залуучуудын шударга ёсыг дээдлэх, ялгаварлан гадуурхахгүй байх, тэдний үзэл бодолд хүндэтгэлтэй хандах

2.1.4. Оролцогч талуудын хамтын ажиллагаа, үр ашигтай түншлэл, залуучуудын орон нутгаа хөгжүүлэх санал, санаачилгад тулгуурласан байх

2.1.5. Хөтөлбөр нь үндэсний болон орон нутгийн бодлого хөтөлбөр, төлөвлөлт, салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоонд тулгуурлах

2.2. Хугацаа: 2018-2020 он

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

3.1 Орон нутгийн залуучуудын хөгжлийг дэмжиж, нийгмийн амьдралд оролцох оролцоог нэмэгдүүлэх замаар эрүүл бие бялдартай, боловсролтой, уламжлалт ёс заншлаа дээдэлсэн, ёс зүйтэй, бүтээлч хариуцлагатай, амьдрах ухааны чадвартай залуу үеийг төлөвшүүлэхэд оршино.

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ

4.1. Залуучуудын хувь хүний хөгжлийг дэмжих, эерэг хандлага, зан үйлийг төлөвшүүлэх, залуу гэр бүлийг дэмжих

4.2. Залуучуудын боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх

4.3. Залуучуудад эрүүл амьдрах мэдлэг, хандлага, зан үйлийг төлөвшүүлж, тэдэнд ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх

4.4. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдлийг бууруулах

4.5. Залуучуудын аюулгүй амьдрах, хөгжих, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчинг нэмэгдүүлэх

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

5.1. Залуучуудын хувь хүний хөгжлийг дэмжих, эерэг хандлага, зан үйлийг төлөвшүүлэх, залуу гэр бүлийг дэмжих зорилтын хүрээнд:

5.1.1. Залуучуудын хувь хүний хөгжлийг дэмжиж амьдрах ухааны цогц сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах /сургагч багш, орон нутгийн сургалт, хэлэлцүүлэг, идэвхжүүлэх үйл ажиллагаа/

5.1.2. Зорилтот бүлгийн залуучуудыг нийгэмшүүлэх, эерэг хандлага төлөвшүүлж, хэвшүүлэх олон талт үйл ажиллагааг зохион байгуулах /сайн үйлсийн аян/

5.1.3. Залуучуудын сайн дурын клуб, сонирхлын бүлгийг үүсгэн байгуулах, хамрагдаж буй залуучуудын оролцоог дэмжих, олон талт хамтын ажиллагааг нэмэгдүүлэх. (уулзалт, сургалт, аян, туршлага судлуулах)

5.1.4. Залуучуудыг гэр бүл, эцэг эх болоход бэлтгэх, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, гэр бүлийн зөвлөгөө өгөх үйлчилгээ хэрэгжүүлэх /Гэр бүлийн үнэ цэнэ чуулган, Угийн бичиг хөтлөх, хүүхдээ эерэг аргаар хүмүүжүүлэх сургалт, уулзалт ярилцлага, гэр бүлд зөвлөгөө өгөх төв/

5.1.5. “Гэр бүлийн өдөр”-тэй болох /нөлөөллийн ажил, уриалга/

5.1.6. Сэтгэлзүйн зөвлөгөө өгөх ажилтануудыг чадваржуулах, зөвлөгөө өгөх төвийн үйл ажиллагааг дэмжих

5.1.7. Залуучуудын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх /нөлөөллийн ажил, хөнгөлөлт, урамшуулал/

5.1.8. Орон нутгийн телевизэд залуучуудын цаг, сонин хэвлэлд залуучуудын булан бий болгох. /залуучууд, гэр бүлд чиглэсэн зөвлөгөө, сургалт, хөгжөөнт, танин мэдэхүйн нэвтрүүлэг/

5.1.9. Орон нутгийн хөгжил, бүтээн байгуулалтад хувь нэмрээ оруулж, үр бүтээлтэй ажиллаж байгаа залуучуудыг алдаршуулж, урамшуулах /ажил мэргэжлийн уралдаан, нөлөөллийн ажлууд/

5.1.10. Залуу малчдад чиглэсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх замаар залуу малчдад амьдрах ухаан, харилцаа, гэр бүл төлөвлөлт, эрүүл мэнд, хууль эрх зүйн боловсрол олгох

5.2. Залуучуудын боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

5.2.1. Орон нутгийн 15-34 хүртэлх насны залуучуудын судалгааг нарийвчлан гаргаж нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх.

5.2.2. Ахлах ангийн сурагчдад зориулсан “Мэргэжил сонголт” аяныг хэрэгжүүлэх /сургалт, өдөрлөг, зөвлөгөө, лекц, аян/

5.2.3. Аймгийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан орон нутгийн эрэлттэй ажил мэргэжлийн мэдээллийг гаргаж, бодлого боловсруулах түвшинд уялдуулах /судалгаа гаргах, мэдээлэх, сурталчлах/

5.2.4. Орон нутгийн хүний нөөцийн бодлого, төлөвлөлтөд үндэслэн гадаад, дотоодын их, дээд сургуульд суралцаж буй бакалавр, доктор, гадаадын магистрийн суралцагчдад дэмжлэгийг олгох /Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, УИХ-ын гишүүд болон бусад эх үүсвэрээс/

5.2.5. Орон нутгийн залуучуудыг Мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх сургалтад зуучлах, хамруулах

5.2.6. Бичиг үсэггүй залуучуудын судалгааг гаргаж, залуучуудыг давтан сургах /насан туршийн боловсролын төвд зуучлах/

5.2.7. Манлайлагч залуусыг бэлтгэн, тэднээр дамжуулан зөв зан үйлийг залуучуудад төлөвшүүлэх

5.2.8. Залуу хүн бүр үндэсний бичиг, хэл, соёлоо сайтар судлан суралцах улмаар гадаад хэл сурахыг уриалсан хөдөлгөөн өрнүүлэх

5.2.9 Залуучуудад амьдрах ухаан, ур чадварт суурилсан баялаг бүтээгч мэргэжилтэй ажилтан байх үнэ цэнийг ойлгуулах.

5.3 Залуучуудад эрүүл амьдрах мэдлэг, хандлага, зан үйлийг төлөвшүүлж, тэдэнд ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

5.3.1. Эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийн зөв дадал олгох, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр залуус, залуусдаа нөлөөлөх арга зүйг хөгжүүлнэ. /сургагч багш, аян, оролцоог нэмэгдүүлэх үйл ажиллагаа, ТББ /

5.3.2. Залуучуудад осол гэмтлээс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох сургалт, нөлөөллийн ажлуудыг зохион байгуулах /сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах, анхны тусламж, /

5.3.3. Залуучуудын идэвх оролцоог нэмэгдүүлэх, эерэг зан үйлийг төлөвшүүлэх, эрүүл амьдрах дадал хэвшлийг бий болгох /сургалт, аялал, уралдаан тэмцээн, өдөрлөг/

5.3.4. Өсвөр үе, залуучуудад бэлгийн замаар дамжих халдварт өвчний хор уршиг, үр дагавар, сайн дурын үзлэг шинжилгээний ач холбогдлын талаар сургалт сурталчилгаа нөлөөллийн ажлуудыг зохион байгуулах.

5.3.5. Эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээллийн төв байгуулж, үйл ажиллагааг тогтворжуулах

5.3.6. Нийтээр тэмдэглэх баяр, ёслолын өдрүүдийг архи, тамхигүй зөв боловсон өнгөрүүлэх, архи, тамхины хэрэглээг бууруулах талаар идэвхтэй ажиллаж байгаа байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх

5.4. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдлийг бууруулах

5.4.1. Ажилгүй залуучуудыг хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, нэгдсэн мэдээллийн ашиглалтыг сайжруулах

5.4.2. Шинэ залуу ажилтануудыг ажлын байраар хангах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, ажлын байраар хангасан албан газар байгууллагыг урамшуулах, сурталчлах

5.4.3. Эрэлттэй, нарийн мэргэжил эзэмшсэн залуучуудаа орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжоор хангах.

5.4.4. Ажил эрхэлж буй залуусыг дэмжих, тэднийг мэргэжлээрээ бахархах, туршлага солилцуулах боломжийг бүрдүүлэх

5.4.5. Аж ахуй эрхлэлтийн болон бизнес санаа олох, хайх, хөгжүүлэх, хөдөлмөр аюулгүй ажиллагааны сургалтуудыг эрх бүхий сургалтын байгууллагуудтай хамтран зохион байгуулна

5.4.6. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Политехникийн коллеж төгсөгчдийг эзэмшсэн мэргэжлээрээ ажиллахад нь дэмжлэг үзүүлэх замаар ажлын байр бий болгоно.

5.4.7. Залуучуудын дунд орон нутгийн хэрэгцээнд нийцсэн “Гарааны бизнес”-ийн уралдаан зохион байгуулж, шалгарсан шилдэг бизнес санааг Хөдөлмөр

эрхлэлтийг дэмжих сан, Орон нутгийн хөгжлийн сан, бусад төсөл хөтөлбөрүүдтэй хамтран санхүүжүүлнэ.

5.4.8. Залуучуудыг түр ажлын байраар хангах замаар орлогыг нь нэмэгдүүлэх. /аян, нийтийг хамарсан ажил, бүтээн байгуулалт/

5.4.9. Ахмадын зөвлөх үйлчилгээний хүрээнд хүүхэд, залууст ажлын дадлага, туршлага, мэргэжлийн ур чадварыг нь өвлүүлэх ажлыг зохион байгуулах.

5.4.10. Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын хөдөлмөрлөх нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

5.4.11. Хорих байгууллагаас суллагдсан залуучуудыг ажлын байраар хангахад аж ахуйн нэгж байгууллагад нөлөөлөх, хамтран ажиллах

5.4.12. Хөдөө аж ахуй, газар тариалан эрхлэх болон малчдын залуу халааг бэлтгэх, залуу малчдыг сургах, "Шинэ зууны Илгээлтийн эзэн"-г бий болгох

5.5 Залуучуудын аюулгүй амьдрах, хөгжих, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчинг нэмэгдүүлэх

5.5.1 Залуучуудын нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор залуучуудын салбар зөвлөлийг байгуулж, тэднийг арга зүйгээр дэмжин хамтран ажиллана.

5.5.2. Орон нутагт үйл ажиллагаагаа явуулж буй иргэний нийгмийн байгууллага, сонирхлын клуб, зөвлөлийг чадавхижуулан, тэдний уялдаа холбоог сайжруулна.

5.5.3. "Бид байгальд ээлтэй залуус" нөлөөллийн ажил өрнүүлэх

5.5.4. "Залуучуудын өдөр"-тэй болох /сар бүрийн 25/

5.5.5. Залуучуудын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх орчинг бий болгоход хувийн хэвшилтэй хамтран тэднийг бодлогоор дэмжиж ажиллана. /газар олгох/

5.5.6. Залуучуудын эрэлт хэрэгцээнд нийцсэн зөвлөгөөн, чуулга уулзалт, спорт, урлаг соёлын наадмыг зохион байгуулах.

5.5.7. Залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хөгжих орчин бүрдүүлсэн "Залуучууд хөгжлийн ордон"-той болох

5.5.8. Залуу гэр бүлийг орон сууцжуулах, хямд өртөг бүхий орон сууц худалдан авах, түрээсийн орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлэх санаачлагыг гарган хамтарч ажиллах

5.5.9. Хүүхэд залуучуудыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүний хор уршигийг таниулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах, олон талт нөлөөллийн ажлуудыг зохион байгуулах

5.5.10. Гэмт хэрэг үйлдсэн, үйлдэж болзошгүй болон гэмт хэргийн хохирогч

болсон залуучуудад чиглэсэн нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх төвийг бий болгох

5.5.11. Сумдад хамгаалах байрыг бий болгох

ЗУРГАА. ХҮРЭХ ҮР ДҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр дараах үр дүнд хүрсэн байна.

6.1.1 Залуучуудын амьдрах ухааны ур чадвар дээшилж, нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа ухамсарласан, ёс зүй, эерэг хандлага, манлайллын сургалтанд 16650 залуус хамрагдсан байна.

6.1.2 Залуучуудын гэр бүл төлөвлөлт сайжирч, гэр бүлийн өмнө хүлээх хариуцлага дээшилэхийн зэрэгцээ залуу гэр бүлийн салалт 12 хувиар буурсан байна.

6.1.4 Залуучуудын нэгдсэн мэдээллийн сантай болсон байна.

6.1.4 Эрүүл мэндээ хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд сайн дурын үндсэн дээр нийт залуучуудын 75 хувь хамрагдсан байна.

6.1.5 Ажилгүй залуучуудын 30 хувь нь түр ажлын байраар хангагдаж орлого нь нэмэгдсэн байна.

6.1.6 Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцсэн 2-3 бизнес санааг жил бүр дэмжсэн байна.

6.1.7 Залуучуудын нийгмийн идэвх оролцоо, нутгийн хөгжилд оруулах хувь нэмэр, бүтээлч хандлага нэмэгдсэн байна.

6.1.8 Залуучууд гэмт хэргийн хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх сургалтанд 100 хувь хамрагдаж, тэдний мэдлэг ойлголт нэмэгдэнэ. Гэмт хэргийн тоо 65 хувиар буурсан байна.

6.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр нөлөөг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.

№	Хөтөлбөрийн хэрэгжүүлэх зорилтууд болон шалгуур үзүүлэлтүүд	Суурь үзүүлэлт 2017 он	Хүрэх түвшин		
			2018 он	2019 он	2020 он
4.1. Залуучуудын хувь хүний хөгжлийг дэмжих, эерэг хандлага, зан үйлийг төлөвшүүлэх					
1	Сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд хамрагдсан залуучуудын тоо	1450	Нийт залуучуудын 10%	Нийт залуучуудын 15%	Нийт залуучуудын 20%
2	Сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд хамрагдсан залуу гэр бүлийн тоо	184	Залуу гэр бүлийн 10%	Залуу гэр бүлийн 15%	Залуу гэр бүлийн 20%
3	Гэр бүлийн харилцаа эерэг болсон, салалт буурсан байх	37	2% бууруулна	5% бууруулна	5% бууруулна
4.2. Залуучуудын боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх					
4	Залуучуудын нэгдсэн мэдээллийн сан	Байхгүй		1	
5	Тэтгэлэг авсан оюутны тоо	74	Үе шаттайгаар нэмэгдүүнэ.		
6	"Мэргэжил сонголт" аянд оролцогчийн тоо	1055	1000	1500	1800
7	Насан туршийн боловсрол төвд	240	Бичиг	Бичиг	Бичиг үсэггүй

	зуучлан бичиг үсэгтэй болсон хүний тоо		үсэггүй залуучуудын 20%	үсэггүй залуучуудын 40%	залуучуудын 30%
4.3. Залуучуудад эрүүл амьдрах мэдлэг, хандлага, зан үйлийг төлөвшүүлж, тэдэнд ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх					
8	Эрүүл мэндийн сургалт үйл ажиллагаанд хамрагдсан залуучуудын тоо	судлагдаагүй	Нийт залуучуудын 10%	Нийт залуучуудын 15%	Нийт залуучуудын 20%
9	Осол гэмтлээр нас баралтын тоо	325	3% бууруулна	5% бууруулна	7% бууруулна
10	Эрүүл мэндийн сайн дурын шинжилгээнд хамрагдсан залуучуудын тоо	судлагдаагүй	Нийт залуучуудын 20%	Нийт залуучуудын 25%	Нийт залуучуудын 30%
11	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан залуучуудын тоо	судлагдаагүй	Нийт залуучуудын 10%	Нийт залуучуудын 20%	Нийт залуучуудын 30%
12	Сайн дурын зөвлөгөө мэдээллийн төвийн тоо	1 /стандарт биш/		1	
13	БЗДХ-аар өвчилсөн залуучуудын тоо	608	2% бууруулна	15% бууруулна	20% бууруулна
4.4. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдлийг бууруулах					
14	Хөтөлбөрийн хүрээнд дэмжлэг авсан бүлгийн тоо	5	4	3	3
15	Хөтөлбөрийн хүрээнд бий болсон ажлын байрны тоо	Гарааны бизнес	-	7	8
		МСҮТ болон Политехникийн коллеж төгсөгч	33	10	11
		Бусад			
16	Түр ажлын байраар хангагдсан залуучуудын тоо	535	Ажилгүй залуучуудын 10%	Ажилгүй залуучуудын 10%	Ажилгүй залуучуудын 10%
4.5. Залуучуудын аюулгүй амьдрах, хөгжих, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчинг нэмэгдүүлэх					
17	Залуучуудын салбар зөвлөлийн тоо	2	20	Үйл ажиллагаа тогтворжсон байна	
18	Залуучуудын сонирхлын бүлэг, клуб	Бүлэг клубын тоо	5	5	10
		Оролцогчийн тоо	176	60	95
19	Гэмт хэрэгт холбогдсон залуучуудын тоо	329	15% бууруулна	20% бууруулна	30% бууруулна
20	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хор уршигийг таниулах сургалт үйл ажиллагаанд хамрагдсан залуучуудын тоо	3000	6000	9000	15000

ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

7.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

7.1.1. Улсын болон орон нутгийн төсөв

7.1.2. Олон улсын байгууллага болон төсөл хөтөлбөрийн дэмжлэг

7.1.3. Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив тусламж

7.1.4. Орон нутгийн хөгжлийг дэмжих сан

7.1.5. Бусад эх үүсвэр

НАЙМ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

8.1. Аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, Залуучуудын төрийн болон төрийн бус байгууллага, нэгдэл, клуб, зөвлөл, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл оролцсон хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулна.

8.2. Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын хэсэг нь нэгдсэн төлөвлөгөө гаргаж ажиллана.

8.3. Төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлд өгсөн үнэлгээ, дүгнэлтийг үндэслэн зөвлөмж гаргаж, цаашдын үйл ажиллагаанд тусгаж ажиллана.

8.4. Хөтөлбөр нь орон нутгийн Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн болон төрийн бус байгууллага, сайн дурын үүсгэл санаачлагын байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжих бөгөөд холбогдох байгууллагууд хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд гарч буй ололт амжилт, ахиц өөрчлөлт, үр дүнг олон нийтэд мэдээлэх, сурталчилах үйл ажиллагааг ил тод, нээлттэй зохион байгуулна.

8.5. Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, жил бүрийн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлнэ.

8.6. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх мэдээ, тайланг аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Залуучуудын хөгжлийн төвийн албан ёсны цахим хуудсаар дамжуулан олон нийтэд, ил тод, нээлттэй мэдээлнэ.

ЕС. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

9.1. Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын хэсэг нь хэрэгжилтийн тайланг нэгтгэж, хагас, бүтэн жилээр аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсээр хэлэлцүүлж, аймгийн Засаг даргын зөвлөл, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанд тайлагнана.

9.2. Төслийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн үнэлгээг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс хариуцан жил бүр хийнэ.

9.3. Сумдын засаг дарга хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ.